

ХОЛБОО БАРИХ – БИОМЕТРИЙН ӨГӨГДӨЛ АВАХ ГАЗРУУД

Oddělení pobytu cizinců = Хэсэг - гадаадын иргэдийн оршин суулт  
Regionální oddělení pobytu cizinců = Орон нутгийн хэсэг - гадаадын иргэдийн оршин суулт


**Прага**  
**Oddělení pobytu cizinců Praha I**  
(зөвхөн байнгийн оршин суух зөвшөөрөлд холбоотой асуудлаар)  
**Nad Vršovskou horou 88/4, Praha 10 – Michle (Bohdalec)**, утас: 974 847 711  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–15.00 | Ба: 8.00–11.00

**Oddělení pobytu cizinců Praha II**  
**Zborovská 1505/13, Praha 5 – Smíchov**, утас: 974 882 690  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–15.00 | Ба: 8.00–11.00

**Oddělení pobytu cizinců Praha III**  
**Cigánkova 1861/2, Praha 4 – Chodov**, утас: 974 820 666  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–15.00 | Ба: 8.00–12.00

**Oddělení pobytu cizinců Praha IV**  
**Koněvova 188/32, Praha 3 – Žižkov**, утас: 974 820 409, 415  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–15.00 | Ба: 8.00–12.00

**Oddělení pobytu cizinců Praha V**  
**Nad Štolou 3, Praha 7 – Holešovice (Letná)**, утас: 974 833 142  
Ажлын цагийн хуваарь:  
Да, Лх: 8.00–12.00, 12.30–15.00 | Мя, Пү: 8.00–12.00, 12.30–16.00 | Ба: 8.00–11.00



**Төвчөх аймаг**  
**Oddělení pobytu cizinců Rakovník**  
**Dukelských hrdinů 2319**, утас: 974 880 426  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00

**Oddělení pobytu cizinců Mladá Boleslav**  
**Štefánikova 1304**, утас: 974 877 471  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00

**Oddělení pobytu cizinců Kutná Hora**  
**Hornická 642**, утас: 974 875 426  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00

**Устецкий аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Ústí nad Labem**  
**Masarykova 27**, утас: 974 420 340  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00

**Oddělení pobytu cizinců Chomutov**  
**Beethovenova 5689**, утас: 974 443 158  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00

**Либерец аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Jablonec nad Nisou**  
**Podhorská 564/62**, утас: 974 474 801  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00

**Краловехрадецки аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Hradec Králové**  
**Ulrichovo nám. 810/4**, утас: 974 520 791  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–11.30 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Пардубице аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Pardubice**  
**Bulharská 936**, утас: 974 560 781  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–11.30 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Плзень аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Plzeň**  
**Slovanská alej 2046/26**, утас: 974 320 290  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–12.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Карловары аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Karlovy Vary**  
**Krýmská 47/1598**, утас: 353 226 683  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Өмнөдчех аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců České Budějovice**  
**Pražská třída 1257/23**, утас: 974 226 851, 859  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–12.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Высочина аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Jihlava**  
**Vrchlického 2627/46**, утас: 974 266 832  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–12.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)


**Өмнөдморави аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Brno**  
**Hněvkovského 30/65**, утас: 543 213 313, 543 214 316  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Моравслези аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Ostrava**  
**Výstavní 55/117**, утас: 974 725 897, 899  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–14.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Оломоуци аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Přeov**  
**U Výstaviště 3183/18**, утас: 974 760 393, 394  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–12.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

**Злин аймаг**  
**Regionální oddělení pobytu cizinců Zlín**  
**Pod Vrškem 5360**, tel.: 974 662 820  
Ажлын цагийн хуваарь: Да, Лх: 8.00–17.00 | Мя, Пү: 8.00–12.00 | Ба: 8.00–11.00  
(дуудлагын дагуу)

Мэдээллийн утас:  
**974 832 418, 974 832 421**  
(Да-Ба: 8.00–16.00)  
Мэдээллийн и-мэйл:  
**robu@mvcs.cz**  
Веб:  
**www.mvcs.cz/cizinci**  
Авиглагын эсрэг  
мэдээлэл өгөх утас:  
974 847 704  
2011 оны 4-р сар



БИОМЕТРИЙН  
ӨГӨГДЛҮҮД  
БНЧУ- Д  
ОРШИН СУУХ  
ЗӨВШӨӨРЛИЙН  
ҮНЭМЛЭХД

ГУРАВДАГЧ ОРНЫ ИРГЭДЭД  
ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY

2011 ОНЫ 5-Р САРААС  
МӨРДӨГДӨНӨ /ХҮЧИНГЭЙ

**2011 оны 5-р сараас эхлэн БНЧУ-д оршин суух зөвшөөрлийн, биометрийн өгөгдөл** агуулсан үнэмлэх олгож эхэлнэ, энэ нь – тусгай техник төхөөрөмжөөр авсан нүүрний зураг ба хурууны хээ.

Энэ үйлдлийн улмаас, **БНЧУ-д амьдарч буй гуравдагч орны иргэдэд зориулсан өөрчлөлтүүд гарна** – **Европын холбооны иргэд ба тэдний гэр бүлийн гишүүдэд эдгээр өөрчлөлтүүд хамаарахгүй.** Мөн БНЧУ-д удаан хугацааны визний үндсэн дээр оршин сууж буй, удаан хугацааны ба байнгийн оршин суух зөвшөөрөл хүсээгүй гуравдагч орны иргэдэд хамаарахгүй.

**Яагаад биометрийн өгөгдлүүдийг авч байгаа вэ?** Биометрийн өгөгдөл авснаар оршин суух үнэмлэхийг хуурамч бус гэдгийг мөн түүнийг эзэмшигчийн биений байцаалтын мэдээллүүдийг илрүүлнэ – гуравдагч орны иргэд. Биометрийн өгөгдлүүдийг (мөн. нүүрний зурагны өгөгдөл) 2011.5.20-оос эхлэн гуравдагч орны иргэдэд Европын холбооны орнуудаас олгох оршин суух зөвшөөрлийн үнэмлэх зайлшгүй агуулах болно.

## ДАРААХЬ ҮЙЛДЛҮҮДЭД ХОЛБОГДУУЛЖ БИОМЕТРИЙН ӨГӨГДЛҮҮДИЙГ АВАХ ҮҮРЭГТЭЙ:

- удаан хугацааны буюу байнгийн оршин суух зөвшөөрөл олгохыг хүсэхэд
- ногоон буюу цнхэр карт олгохыг хүсэхэд
- удаан хугацааны буюу байнгийн оршин суух зөвшөөрөл гардан авах зорилгын үндсэн дээр удаан хугацааны виз олгогдож БНЧУ-д ирсэн тохиолдолд
- оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгуулахыг хүсэхэд
- оршин суух үнэмлэх нөхөн олгохыг хүсэхэд – үнэмлэхээ хаясан, гэмтээсэн, алдсан, эсвэл үнэмлэхний биометрийн өгөгдөл агуулагч зөөгч ажиллагаагүй болсон тохиолдолд
- үнэмлэхний хүчинтэй хугацаа дууссаны дараа буюу үнэмлэхийг хүчингүй болгосон (жнь:үнэмлэхээ гэмтээсний улмаас) шинэ үнэмлэх олгохыг хүсэхэд
- үнэмлэхэд бичигдсэн мэдээлэлд өөрчлөлт орсны улмаас оршин суух зөвшөөрлийн үнэмлэх шинээр олгохыг хүсэхэд.

Биометрийн өгөгдлийг, **бүх газар биш** – сонгосон газрууд авна- **Дотоод хэргийн яамны харъяа** (цаашид зөвхөн „яам“) газрууд, эдгээр газрууд нь тусгай техник төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Та, биометрийн өгөгдөл өгсөн газарт тогтоосон хугацаанд ирж оршин суух үнэмлэхээ гардан авах үүрэгтэй.

**Энэ газар нь таны өргөдөл өгсөн газраас өөр, мөн та БНЧУ-ын нутагт оршин суухтай холбоотой асуудлаар ханддаг байсан газраас тань өөр газар байж болно.**

## ӨӨРИЙН БИЕЭР ОРОЛЦОХ ҮҮРЭГ

Биометрийн өгөгдөлтэй холбогдуулж таньд үүсэх үүрэг:

- яамны харъяа байгууллага газар дээр өөрийн биеэр ирэх** – биометрийн өгөгдөл өгөх, гарын үсгийг дижитал аргаар боловсруулах зорилгоор

- яамны **дуудлагаар\*** ( БНЧУ-ын нутагт өөрийн биеэр буй тохиолдолд)
- БНЧУ-ын нутагт нэвтэрсний дараа **ажлын 3 өдрийн дотор** удаан хугацааны буюу байнгийн оршин суух зөвшөөрөл гардан авах зорилгоор удаан хугацааны виз олгосон тохиолдолд (БНЧУ-ын төлөөлөгчийн байгууллага танд, удаан хугацааны буюу байнгийн оршин суух зөвшөөрөл гардан авах зорилгоор удаан хугацааны виз олгосон)

- биометрийн өгөгдөл өгөх болон дижитал аргаар боловсруулах зорилгоор гарын үсэг өгөх үйлдлийг тэвчин өнгөрөөх

- тогтоосон хугацаанд\*, биометрийн өгөгдөл өгснөөс цаад тал нь 60 хоногийн дотор яаман дээр **өөрийн биеэр** ирж оршин **суух зөвшөөрлийн үнэмлэхээ гардан авна**, учир нь: таны биений байцаалтыг тодруулж, үнэмлэхэнд бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг шалгах, биометрийн өгөгдөл агуулсан зөөгчийн ажиллагааг шалгах .

\*Хэрэв та өргөдөл өгөхдөө утасны дугаараа бичиж үлдээсэн тохиолдолд тантай утсаар холбоо барьж биометрийн өгөгдөл өгөх хугацаа, мөн оршин суух үнэмлэхээ гардан авах хугацааг тохирно. Хэрэв та, утасны дугаар орхиогүй тохиолдолд биометрийн өгөгдөл өгөх хугацаа, мөн оршин суух үнэмлэхээ гардан авах хугацааг танд бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд та хэзээ ирэх тухайгаа урьдчилж утсаар захиалга өгнө – холбоо барих хэсгийг үзнэ үү.

Анхааруулга: Байнгийн оршин суух зөвшөөрөл олгох шийдвэр буюу байнгийн оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийн хугацааг сунгах **шийдвэрийг гардаж авсны дараа бэлэн болсон үнэмлэхээ ирж авахгүй** тохиолдолд танд 10 000 хүртэлх чех кроны торгууль ногдуулна. Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл олгосон үнэмлэх ба түүний хугацааг сунгасны дараа ирж аваагүй тохиолдолд Таны өргөдлийг авч хэлэлцэн шийдэх ажиллагааг зогсооно.

**Оршин суух зөвшөөрлийн үнэмлэх – биометрийн өгөгдөл агуулаагүй'** 2011 оны 5-р сар хүртэлхи хугацаанд олгосон үнэмлэхүүд тэдгээрийн хугацааг дуустал хүчинтэй, үнэмлэхэнд бичигдсэн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг биометрийн өгөгдөл агуулсан үнэмлэх олгоход оруулна. Оршин суух зөвшөөрлийн шинэ үнэмлэх олгох зорилгоор биометрийн өгөгдөл ирж өгөх тухай яамнаас дуудлага илгээнэ. (2011 оны 5-р сараас наана биш).

**Үнэмлэхэнд бичигдсэн мэдээтэлд орсон өөрчлөлтийг мэдэгдэх** Үнэмлэхэнд бичигдсэн мэдээлэлд **өөрчлөлт** орсон тохиолдолд (жнь: овгийн өөрчлөлт) та, энэ тухай өөрчлөлт орсноос хойш ажлын 3 өдрийн дотор яаманд мэдэгдэх үүрэгтэй. Оршин суух хаягийн өөрчлөлтийг та дараахь маягаар мэдэгдэх үүрэгтэй:

- өөрчлөлт орсноос хойш 30 өдрийн дотор, хэрэв оршин суух хаягийн өөрчлөлт 30 хоногоос хэтэрсэн тохиолдолд (удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд) буюу
- өөрчлөлт орсноос хойш 30 өдрийн дотор, хэрэв оршин суух хаягийн өөрчлөлт 180 хоногоос хэтэрсэн тохиолдолд (биангийн оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд).

**Төлөөлүүлэх боломж**

Яамтай харьцах дараахь асуудалд- удаан хугацааны оршин суух зөвшөөрөл олгох болон удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахыг хүссэн өргөдөл гаргах, та өөр хүнд бичгэн итгэмжлэх олгосны үндсэн дээр тэр хүн тань таныг төлөөлж болно. Гэвч энэ нь удаан хугацааны ба байнгийн оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахтай холбоотой  биометрийн өгөгдөл өгөхөд хамаарахгүй.

**Албаны хураамж**

Биометрийн өгөгдөл агуулсан үнэмлэхтэй холбоотой үйлдэлд, албаны хураамжийн тухай хуулийн дагуу дараахь хураамжийг авна (марк хэлбэрээр, шуудангаас худалдан авч болно):

- оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгох ба түүний хугацааг сунгахад: 2500 чех крон (15 хүртэлхи насны хүүхэд 1000 чех крон )
- оршин суух зөвшөөрлийн үнэмлэхэнд өөрчлөлт: 1000 чех крон
- үнэмлэхээ хаясан, гэмтээсэн, алдсан,  эсвэл үнэмлэхний биометрийн өгөгдөл зөөгч ажиллагаагүй болсон тохиолдолд нөхөн оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгоход: 4000 чех крон (15 хүртэлхи насны хүүхэд 2500 чех крон)

## ХҮМҮҮСИЙН ЗҮГЭЭС БАЙНГА ТАВИАГДДАГ АСУУЛТУУД

**Биометрийн өгөгдөл өгөхөөс татгалзаж болох уу?** Болохгүй, гуравдагч орны иргэд биометрийн өгөгдөл өгөх үүрэгтэй, (Европын холбооны гишүүн орны иргэний гэр бүлийн хүмүүст хамаарахгүй), гуравдагч орны иргэдэд, удаан хугацааны буюу байнгийн оршин суух зөвшөөрөл олгосны үндсэн дээр үнэмлэх олгоно. (103-р зүйлийн к үсэгт заасан ).

**Ямар тохиолдолд биометрийн өгөгдөл авахгүй вэ?** Зарим тодорхой нөхцөлд гарын хээ авахгүй – анатоми физилогийн өөрчлөлтийн улмаас, жнь: гарын хуруу эрүүл мэндийн үүднээс гэмтэж бэртсэн. Энэ тохиолдолд оршин суух зөвшөөрлийн үнэмлэх нүүрний зурагны өгөгдлийг агуулна. (117a-р зүйл).

**Хүүхдийн хувьд ямар дүрэмтэй вэ?** 6 хүртэлхи насны хүүхдээс зөвхөн нүүрний зураг авна.

**Миний одоо эзэмшиж буй үнэмлэх биометрийн өгөгдөл агуулаагүй- шинэ үнэмлэх олгохыг би хүсэх үүрэгтэй юу?** Таны одоо эзэмшиж буй үнэмлэх хугацаа дуусах хүртлээ хүчинтэй. Биометрийн өгөгдөл агуулсан үнэмлэх танд дараахь тохиолдлуудад холбогдуулж олгоно:

- удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулахад (зөвшөөрлийн хугацаа дуусахаас наад зах нь 90 хоногийн өмнө, цаад зах нь 14 хоногийн өмнө та өргөдөл өгөх үүрэгтэй) буюу
- байнгийн оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийн хугацаа сунгуулахад (үнэмлэхийн хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө та өргөдөл өгөх үүрэгтэй) буюу
- оршин суух зөвшөөрлийн шинэ үнэмлэх олгох шаардлагатай үед (жнь: одоо эзэмшиж буй үнэмлэхэнд бичигдсэн мэдээлэлд өөрчлөлт орсонтой холбогдуулж).

**Миний биометрийн өгөгдлүүдийг яах вэ?** Оршин суух зөвшөөрөл олгохтой холбогдуулж авсан таны биометрийн өгөгдлүүдийг оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийн мэдээлэл зөөгчид байрлуулах ба мөн гадаадын иргэдийн мэдээллийн системд бүртгэгдэнэ. Мэдээллийг, хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн заалтын дагуу хадгална, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх хүчингүй болсноос 60 хоногийн дотор мэдээллийг арилгана. (160-р зүйлийн 7-р хэсэг).

**Мэдээлэл агуулагч зөөгчийн ажиллагааг шалгаж болох уу?** Болно, мэдээлэл зөөгчийн ажиллагааг шалгах хүсэлт та яаманд гаргаж болно. Хэрэв ажиллагаагүй болох нь илэрвэл, таны буруугаас бус, шинэ үнэмлэх төлбөргүй олгох хүсэлт гаргаж болно. (117a-р зүйл).

Эдгээр мэдээлэл, мөн дурьдсан хуулийн зүйл ангиуд нь **БНЧУ-ын нутагт гадаадын иргэд оршин суух тухай хуули**нд наад захын зүг чиг олох зорилгоор хэрэглэв. (БНЧУ-ын нутагт гадаадын иргэд оршин суух тухай  326/1999 Sb., тоот хууль).

<sup>[1]</sup> Паспортын хуудсан дээр шошго хэлбэртэй наасан байгаа